



## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг<sup>1</sup>)

### ЦАХИМ БИРЖИЙН СИСТЕМИЙН АЛДААГ АШИГЛАН КРИПТОВАЛЮТ АРИЛЖААЛАН АШИГ ОЛСОН ҮЙЛДЛИЙГ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ҮЗЭВ

**САНАМЖ:** Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

**Шүүхийн шийдвэрийн дугаар:** ХШТ/2026/01

**Шүүхийн шийдвэрийн огноо:** 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

**Шийдвэрийн төлөв:** Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулсан.

#### ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч Э, М, Б нар нь “Т” ХХК-ийн цахим биржийн системийн алдааг ашиглан 0 төгрөгийн захиалгаар криптовалют худалдан авч, арилжаанд оролцсон. Улмаар 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хүртэлх хугацаанд “Т” ХХК-д Э 371 удаагийн үйлдлээр 51,488,521 төгрөг, М 342 удаагийн үйлдлээр 39,301,641 төгрөг, Б 336 удаагийн үйлдлээр 31,128,603 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

#### ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- 1. Анхан шатны шүүхээс** шүүгдэгч Э-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-т<sup>2</sup> заасан үргэлжилсэн үйлдлээр бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар хулгайлан авч **их хэмжээний хохирол учруулан хулгайлах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож**, 2 жилийн хорих ялаар шийтгэжээ. Харин шүүгдэгч М, Б нарыг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт<sup>3</sup> заасан үргэлжилсэн үйлдлээр бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар хулгайлан авч **бага хэмжээнээс дээш хэмжээний хохирол учруулж хулгайлах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож**, 1 жилийн хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялаар тус тус шийтгэжээ.
- 2. Давж заалдах шатны шүүхээс** анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

<sup>1</sup> Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

[https://shuukh.mn/single\\_case/3811?daterange=2025-01-01%20-%202025-12-31&id=3&court\\_cat=2&bb=1](https://shuukh.mn/single_case/3811?daterange=2025-01-01%20-%202025-12-31&id=3&court_cat=2&bb=1), (Сүүлд үзсэн: 2026.06.09).

<sup>2</sup> Эрүүгийн хууль (2015)-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.3 дахь заалт “Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч их хэмжээний хохирол учруулсан бол 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

<sup>3</sup> Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”



3. **Шүүгдэгч нарын өмгөөлөгч шүүхэд гаргасан гомдолдоо** “...анхан болон давж заалдах шатны шүүх хулгайлах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрэн дүгнээгүй, программын алдаа болон криптовалюта хулгайлах гэмт хэргийн халдлагын зүйл болох эсэхийг хангалттай тогтоогоогүй, мөн 4 оронтой зөвшөөрлийн код өгсөн үйл явцыг “нууц далд аргаар” гэж үзсэн нь үндэслэлгүй” гэжээ.
4. **Хяналтын шатны шүүхээс** хоёр шатны шүүхийн хэргийн үйл баримтыг тогтоосон дүгнэлт бодит байдалтай нийцжээ. **Нөгөөтээгүүр, хоёр шатны шүүх шүүгдэгч Э, М, Б нарыг хулгайлах гэмт хэргээр зүйлчлэн, Эрүүгийн хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна.**(43)<sup>4</sup>
5. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар бүлэгт заасан өмчийн эсрэг гэмт хэргүүд нь бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхэд халддаг нийтлэг шинжтэй хэдий ч **хулгайлах болон залилах гэмт хэргүүд нь халдлагын арга, хохирогчийн хүсэл зоригоос хамаарч эрс ялгагдана.**(46)
6. Хулгайлах болон залилах гэсэн хоёр гэмт хэргийг зүйлчлэхдээ объектив талын шинж буюу гэмт үйлдлээ гүйцэтгэхдээ сонгосон аргыг гол шалгуур болгодог.(47)
7. Энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн “Шударга ёсны зарчим” болон “Нэг удаа ял шийтгэх зарчим”-ыг баримтлан, тухайн үйлдлийн мөн чанарыг хамгийн бүрэн дүүрэн, нарийвчлан илэрхийлж буй зүйл, заалтыг сонгож хэрэглэх ёстой.(48)
8. Гэмт хэргийн объектив талын шинжээр хулгайлах гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч үйлдэгддэг бол залилах гэмт хэрэг хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах зэрэг аргаар үйлдэгддэг.(50)
9. **Хулгайлах болон залилах гэмт хэргийг ялгахдаа хохирогчийн хүсэл зоригийн илэрхийллээр заагладаг.** Учир нь залилах гэмт хэргийн хохирогч бусдын хуурмаг үйлдэлд төөрөгдсөний улмаас эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээ гэмт этгээдэд өөрийн хүсэл зоригоор, сайн дурын үндсэн дээр шилжүүлэн өгсөн байдгаараа онцлогтой. Харин хулгайлах гэмт хэрэг нь өмчлөгч, эзэмшигчид мэдэгдэхгүйгээр, түүний хүсэл зоригоос гадуур, зөвшөөрөлгүйгээр, нууц, далд аргаар эд хөрөнгийг авсан байдгаар ялгагдана.(52)
10. Цахим орчинд мэдээллийн системд нэвтрэх эрхгүй этгээд хамгаалалтын системийг эвдэх (хакердах), нууц үгийг хууль бусаар олж авах, эсхүл техник, программ хангамжийн аргаар хууль бусаар нэвтэрч, серверийн аюулгүй байдлыг эвдэж өмчлөгч, эзэмшигчид мэдэгдэхгүйгээр хөрөнгийг шилжүүлэн авсан үйлдэл хулгайлах гэмт хэрэгт тооцогдоно. Энэ тохиолдолд систем нь хөрөнгийг шилжүүлэх хүсэл зоригоо илэрхийлээгүй, харин гэмт этгээд хүчээр буюу хууль бус нэвтрэлтээр хөрөнгийг авах шинжтэй байдаг.(64)
11. **Харин цахим орчинд программ хангамжийн алдаа, цоорхойг ашиглан хуурамч, ойлгомжгүй өгөгдөл оруулах, гүйлгээний агуулга, утгыг өөрчлөх зэргээр мэдээллийн системийг төөрөгдүүлж, улмаар системээр дамжуулан хөрөнгө шилжүүлэх зөвшөөрлийг авч буй үйлдэл залилах гэмт хэрэгт хамаарна.**(65)

<sup>4</sup> “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



12. Криптовалют нь биет бус шинжтэй боловч зах зээл дээр тодорхой үнэлгээтэй, бусдад шилжүүлэх, арилжаалах боломжтой, эдийн засгийн үнэ цэнтэй, хэмжигдэхүйц байх тул Эрүүгийн хуулиар хамгаалагдсан өмчлөх эрхийн объектод хамаарна.(83)
13. Шүүгдэгч нарын үйлдэл бусдын эд хөрөнгийг нууцаар авсан ерөнхий шинжийг агуулсан хэдий ч залилах гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан байна.(70)
14. Иймд хяналтын шатны шүүхээс өмгөөлөгчийн гаргасан гомдлыг хангаж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4-т<sup>5</sup> заасны дагуу шийтгэх тогтоолд “шүүгдэгч Э-г ЭХТА-ийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2-т<sup>6</sup> заасан гэмт хэрэгт гэм буруутайд тооцож, 2 жилийн хорих ял оногдуулж, шүүгдэгч М, Б нарыг ЭХТА-ийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг<sup>7</sup> заасан гэмт хэрэгт гэм буруутайд тооцож, 1 жилийн хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялаар тус тус шийтгэсүгэй” гэх өөрчлөлт оруулж, шийтгэх тогтоол, магадлалын бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.(96)

---oOo---

<sup>5</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.4 дахь хэсэг “хяналтын шатны шүүх нь хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах шийдвэр гаргана.”

<sup>6</sup> Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2-т “Хуурч, ... цахим хэрэгсэл ашиглаж, зохиомол байдлыг зориудаар бий болгож, бусдыг төөрөгдөлд оруулж, ... эд хөрөнгийг шилжүүлэн авсан гэмт хэргийг их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол 10.000-40.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

<sup>7</sup> Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Хуурч, ... цахим хэрэгсэл ашиглаж, зохиомол байдлыг зориудаар бий болгож, бусдыг төөрөгдөлд оруулж ... эд хөрөнгийг шилжүүлэн авсан бол 450-14,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”